



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 14 зүйлийн 2 дахь хэсгийн 4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн (бүрэлдэхүүн сургууль, нэгж)-ийн албан хэрэгцээнд зориулан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 2023 онд нэмж 3,000,000,000.00 (гурван тэрбум) төгрөгт багтаан үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрч, санхүүжилтийн дүн, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирал Н.Хүрэлбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Худалдан авсан хөрөнгийг бүртгэлд тусгах, энэ тогтоолын биелэлтийг тайлагнах ажилд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн
 103 дугаар тогтоолын хавсралт

**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ (БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ, НЭГЖ)-ИЙН
 ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР 2023 ОНД ОЛЖ АВАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ (НЭМЭЛТ)**

Д/д	Эргэлтийн бус хөрөнгийн төрөл, нэр	Хэмжих нэгж, тоо хэмжээ	Барьж эхэлсэн (эхлэх) он	Нийт төсөвт өртөг (төгрөг)	Санхүүжилт хийсэн дүн (2022.12.31-ний байдлаар, төгрөг)	Барилгын гүйцэтгэлийн хувь (%)	2023 онд зарцуулах санхүүжилтийн дүн (төгрөг)
	1.Барилга байгууламж						
1	Эрхэс сувилал 100 ортой сувиллын барилгын ажил	1	2021	11,890,442,985.00	95,000,000.00	3%	3,000,000,000.00
	НИЙТ ДҮН						3,000,000,000.00 (гурван тэрбум)